



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 4/519

Зуунмод

Г Ажлын хэсэг байгуулах тухай

Сумдын жигд хөгжлийг хангах, хөрөнгө оруулалт, их засварын ажлын төсөл, арга хэмжээний санал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, эрэмбэ дарааллыг оновчтой тогтоож хуваарилах зорилгоор “Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29.1.6, 29.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын төсөвт байгууллагуудын барилга байгууламж, дулааны болон цахилгаан эрчим хүчний байгууламж, шугам сүлжээ, Засаг даргын Тамгын газрын болон эрүүл мэндийн төвийн автомашин, тоног төхөөрөмжийн чанар байдал, хүрэлцээ хангамжийг газар дээр нь үзэж үнэлэлт дүгнэлт өгөх, хөрөнгө оруулалт хийх эрэмбэ дарааллыг оновчтой тогтоож ишийдвэрлүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсугай.

1-р ажлын хэсэг:

Ахлагч:

Ю.Бямбацогт ✓

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гиниүүд:

Э.Мөнгөнсэлэнгэ ✓

-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Д.Алтансүх

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ерөнхий архитектур, хэлтсийн дарга

2-р ажлын хэсэг:

Ахлагч:

М.Хүрэлбаатар

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Гиниүүд:

П.Баярсайхан

-Боловсрол, соёл урлагийн газрын төсвийн мэргэжилтэн

Д.Энхжаргал ✓

-Санхүү, төрийн сангийн хэлтсийн орон нутгийн өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн

3-р ажлын хэсэг:

Ахлагч:

Д.Батжаргал

-Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:
П.Дэмчигжав ✓

-ХОХБТХ-ийн барилга, хот байгуулалт, зам тээвэр,
газрын харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Батзориг

-Эрүүл мэндийн газрын эмзэлгийн тоног
төхөөрөмж, засвар үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

4-р ажлын хэсэг:

Ахлагч:
М.Мэндсүрэн ✓

-Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:
Д.Цогтсайхан

-ГХБХБГ-ын барилгын техник хяналтын инженер

Ц.Нарантуяа
С.Тахчук —

-Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын
бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн явах чиглэл, ажиллах автомашин, шаардагдах шатахууны тооцоог нэгдүгээр, хийгдэх ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


3. Шатахууны зардалд шаардагдах 1.046.510 /Нэг сая дөчин зургаай мянга таван зуун арван төгрөг/-ийг шилжих үлдэгдэлээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ю.Бямбацогт/-д, зарцуулахыг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Отгоибат/-д тус тус зөвшөөрсүгэй.

4. Удирдамжийн дагуу үзлэг шалгалтыг зохион байгуулж, судалгаа мэдээллийг авч, зурагжуулан баримтлуулж, үр дүнг нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч нарт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж чиглэлээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч /Д.Мөнхбаатар/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ



Аймгийн Засаг дарын 2016 оны
09 дүгээр сарын 08-ны өдрийн
4519 дугаар захирамжийн 1-р хавсралт

**АЖЛЫН ХЭСГИЙН ЯВАХ ЧИГЛЭЛ, АЖИЛЛАХ АВТОМАШИН,
ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТӨОНОО**

№	Ажлын хэсэг	Ажиллах сумд	Ажиллах автомашины марк, дугаар	Нийт км	Зарцуулах	
					Шатахуун /л/	Мөнгөн дүн /төгрөг/
1	1-р ажлын хэсэг	Зуунмод, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Дэлгэрхаан, Өндөрширээт, Алтанбулаг	94-09 ТӨА	1054	179	254.180
2	2-р ажлын хэсэг	Зуунмод, Заамар, Цээл, Угтаалцайдам, Лүн, Эрдэнэсант, Баянхангай, Аргалант	Ланд-200 91-99 ТӨВ	966	212	311.640
3	3-р ажлын хэсэг	Зуунмод, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Баян, Баянжаргалан, Сэргэлэн	00-04 ТӨА	991	218	320.460
4	4-р ажлын хэсэг	Зуунмод, Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянчандмань, Баянцогт	20-00 ТӨВ	842	109	160.230
ДҮН						1.046.510

Аймгийн Засаг даргын 2016 оны
09 дүгээр сарын 08-ны өдрийн
4579 дугаар захиралжийн 2-р хавсралт

**ОРОН НУТАГТ АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН
УДИРДАМЖ**

НЭГ. Томилолтын зорилго:

Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих хөрөнгө оруулалт, их засварын ажлын төсөл, арга хэмжээний санал, хэрэгтийн шаардлагыг тодорхойлох, өмнөх жилүүдэд сумдад хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтгэй танилцаж, гүйцэтгэлийг хянаж, дүгнэлт гаргах, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшилүүлэх талаар санал дүгнэлт гаргахад оршино.

ХОЁР. Ажиллах хугацаа:

2016 оны 09 дүгээр сарын 9, 10-ид Зуунмод суманд, 09 дүгээр сарын 12-ны өдрөөс 18 хүртэл бусад хуваарыт сумдадаа ажилдана.

ГҮРАВ. Хийж гүйцэтгэх ажлууд:

3.1 Орон нутгаас авах мэдээллийн маягтыг боловсруулай, тухайн суманд ажиллах ажлын хэсгийн ахлагч урьчилан хүргүүлж зааварчилгаа өгч бөглүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

3.2 2013 онд 4 яамны ажлын хэсэг явж иэг загвараар гаргасан сумын эдийн засаг, нийгмийн танилцуулгыг шинэчлэн зурагжуулан баяжуулж цаас болон файлаар гаргуулан авч, мэдээллийн маягт хавсралтуудыг үнэн зөв бөглөсөн эсэхийг газар дээр нь үзэж нягтлан, гарын үсэг зурж хүлээж авна.


3.3 Тухайн суманд байгаа төрийн суурь үйлчилгээ үзүүлж буй барилга, дэд бүтцийн байгууламжуудыг бүрэн хамруулж үзэж, зурагжуулж баримтжуулан мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, санал дүгнэлт гарган, хөрөнгө оруулалт, их засвар хийх жагсаалтаар эрэмбэлж авна.

3.4 Баригдаж байгаа болон чанаргүй, стандартын шаардлага хангаагүй барилга байгууламжийн чанар, ашигласан материал, хийц, эзэлхүүний стандарт ямар байгаа талаар ажлын хэсгийн дүгнэлт гарган авах арга хэмжээний санал боловсруулж тайланд тусгана.

ДӨРӨВ. Үр дүнг тайлагнах:

4.1 Албан томилотгоор ажилласнаас хойшхи ажлын 2 хоногийн хугацаанд ажлын хэсгүүд мэдээллээ аймгийн Засаг даргын орлогч даргад танилцуулж, цаасан болон цахимаар хүлээлгэн өгнө. Үүнд:

1. Сумын эдийн засаг, нийгмийн танилцуулга
2. Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, обьектууд, шинэчлэх шаардлагатай автомашин, тоног төхөөрөмжийн хувийн хэрэг, мэргэжлийн хяналтын байгууллагын акт, дүгнэлт, баримтжуулсан фото зураг, сумын санал дүгнэлт
3. Эх үүсвэр тус бүрээр эрэмбэлж, баталгаажуулсан хөрөнгө оруулалт, их засварын төсөл, арга хэмжээний эрэмбэлсэн жагсаалт, ажлын хэсгийн санал дүгнэлт
4. Сумын Засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа шинэчлэх шаардлагатай автомашины, тоног төхөөрөмжийн жагсаалт, эрэмбэд оруулж шийдвэрлүүлэх санал дүгнэлт
5. Өмнөх бүрэн эрхийн хугацаанд суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг баримтжуулсан материал, фото зураг, төслийн хэрэгжилтгэй холбоотой санал дүгнэлт
6. Мөн гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрөөр суманд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт, гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой санал дүгнэлт

БАТЛАВ.
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  Ж.БАТЖАРГАЛ

**СҮМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ
СУДАЛГАА ГАРГУУЛАН АВАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

НЭГ. Зорилго:

1. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл эргэн төлөлт, зарцуулалтын дэлгэрэнгүй судалгааг сан хариуцсан нягтлан бодогчдоор гаргуулан авах, сангийн хөрөнгийг төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд оршино.

2. Хугацаа: -2016 оны 09-р сарын 12-ноос 09 дүгээр сарын 18-ны хооронд

ХОЁР. Зохион байгуулалт:

2.1 Сумдын сум хөгжүүлэх сан хариуцсан нягтлан бодогчдоор маягтын дагуу 2009-2016 оны зээл нь дуусаагүй байгаа бүх зээлдэгч нарыг хамруулан дэлгэрэнгүй судалгааг цаас болон файлаар гаргуулан авах

2.2 Монгол улсын Засгийн газрын 2016 оны 03 дүгээр сарын 14-ны өдрийн “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайллагнах, хяналт тавих журам батлах тухай” 153 дугаар тогтоолын хэрэгжилт, сангийн хөрөнгийг эргэн төвлөрүүлэх чиглэлээр сум орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа ажлын үр дүнгийн бичмэл тайланг гаргуулан авах

2.3 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай холбоотой 2016 онд сумын ИТХурлаас гарсан тогтоол, шийдвэрийн хуулбарыг хавсарган авна.

2.4 Зээлийг зориулалтын дагуу ашигласан байдал түүний үр дүнгийн тайланг гаргуулан авах, санал дүгнэлт

ГУРАВ. Үр дүнгийн тайллагнах:

3.1 Сум хөгжүүлэх сангийн судалгаа мэдээлэл, үр дүнгийн тайланг нэгтгэн авч сангийн үйл ажиллагаанд санал дүгнэлт гаргаж, Засаг даргын зөвлөлд ажлын хэсгүүд тайллагнах